

842



**БНМАУ  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1990 оны 12 сарын 28

№ 312

Улаанбаатар хот

**Пүүс байгуулах тухай**

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас  
ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газрын харьяанд ажиллах худалдаа, үйлдвэрлэлийн "Гал голомт" пүүсийг 1991 оны I дүгээр сарын I-нээс эхлэн аж ахуйн бүрэн тооцооны үндсэн дээр ажиллуулахыг Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар /н.Бямбаа/-т зөвшөөрсүгэй.

2. Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар /н.Бямбаа/-т даалгах нь:

а/ "Гал голомт" пүүст харьяа байгууллагуудын материал техникийн хангамж, гадаад харилцаа, бараа солилцоог хариуцан гүйцэтгэх гадаад худалдааны эрх олгуулах асуудлыг зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;


б/ Пүүсийн захиргаа аж ахуйн зардал, цалин, тоног төхөөрөмж худалдан авах, өргөтгөхтэй холбогдсон болон бусад зардлыг 1991 оны 7 дугаар сарын I хүртэл санхүүжүүлэх;


в/ "Гал голомт" пүүсийн дүрэм, эхний ээлжинд мөрдөх орон тоо, цалингийн санг баталж өгөх.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА

  
Л.ЭНЭБИШ

  
Ч.СУМАА ХҮҮ